

**“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2025.12.19

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээний зорилго

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монголын Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтын хүрээнд Биеийн тамир, спортын салбарын хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулж, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээний арга зүй

Хяналт-шинжилгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг удирдлага болгов.

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2025 оны жилийн эцсийн тайланг тухайн зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийг үндэслэн дараах байдлаар дүгнэн тооцлоо.

1. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 85 хувь буюу түүнээс дээш бол “үр дүнтэй”;
2. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 60-84 хувь бол “үр дүн хүлээгдэж байгаа”;
3. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 30-59 хувь бол “үр дүн хангалтгүй”;
4. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 0-29 хувь бол “үр дүн гараагүй”;
5. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.

Гурав. Хяналт-шинжилгээний үр дүн

Биеийн тамир, спортын салбарын хэрэгжүүлэхээр тусгагдсан 2 зорилт 14 арга хэмжээнээс 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд тайлагнавал зохих 9 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд 7 арга хэмжээ 85 хувиас дээш буюу “үр дүнтэй”, 2 арга хэмжээ 60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа” хэрэгжилтийн дундаж 94.4 хувьтай буюу “үр дүнтэй” гэж дүгнэгдлээ.

Мөн Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор “Алсын хараа-2050” Монголын Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтын хүрээнд Биеийн тамир, спортын салбарын хэрэгжүүлэхээр тусгагдсан 5 арга хэмжээ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны чиг үүрэгт шилжсэн тул хэрэгжилт тайлагнагдаагүй байна.

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний хэрэгжилтийн дүн (хувиар)					Дундаж хувь
9	Үр дүнтэй	Үр дүн хүлээгдэж байгаа	Үр дүн хангалтгүй	Үр дүн гараагүй	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	94.4
	85 хувиас дээш	60-84 хувь	30-59 хувь	0-29 хувь	-	
	7	2	-	-	-	

№	Дас дугаар	Зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэл хувь
ЗОРИЛГО 1. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ			
Зорилт 1.5. Дэлхий дахинд монгол үндэсний үнэт зүйлсийн дархлаа тогтож, монгол соёлыг түгээн дэлгэрүүлж, Монгол Улсын нэр хүнд, үнэлэмжийг дээшлүүлж, хилийн чанад дахь монголчууд, монгол угсаатны хамтын ажиллагаа төлөвшинэ.			
1.	1.5.12.	Монголын уламжлалт спорт, наадам, нээдгайг (бөх, сурын харваа, шагайн харваа гэх мэт) хөгжүүлэх, үндэсний бөх, тамирчдаа дэмжих, морин болон тэмээн спортын (морин поло, тэмээн поло) төв байгуулж үндэсний багтай болох, гадаад, дотоодын баг, тамирчдыг урьж тоглуулах тогтолцоог хөгжүүлж, спортын зарим төрлийг олон улсын болон олимпын төрөлд оруулах, түүгээр дэмжүүлэн өөрийн орны соёлыг түгээн дэлгэрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлнэ.	80%
ЗОРИЛГО 3. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА			
Зорилт 3.5. Идэрхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлнэ.			
2.	3.5.1.	Биеийн тамирыг бүх нийтийн хөдөлгөөн болгох, иргэн, гэр бүлийн хэрэгцээнд нийцсэн идэрхтэй амьдралын дадал хэвшил төлөвшүүлэх насан туршийн боловсролын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.	80%
	3.5.2.	Улсын хэмжээнд иргэдийн спортын төрөлжсөн наадмыг 4 жил тутамд зохион байгуулна.	100%
	3.5.3.	Иргэдийн бие бялдрын түвшин тогтоох сорилын үр дүнд, заавал биелүүлэх норм, нормативыг насны ангиллаар тогтоож, мөрдүүлнэ.	100%
	3.5.4.	Хүн амын идэрхтэй амьдралын хэв маягийг дэмжих, идэрхтэй амьдралын аж төрөх ёсны хэрэглээг дэмжсэн судалгаа, сургалт, сурталчилгааг нэмэгдүүлнэ.	100%
	3.5.5.	Олон улсын шаардлага, стандартад нийцсэн орчинд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	100%
	3.5.6.	Биеийн тамир, спортын үйлчилгээний төрөл, гүйцэтгэлтэй уялдсан хараат бус магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагыг нэвтрүүлнэ.	ССАЖЗЯ
	3.5.7.	Биеийн тамир, спортын санхүүжилтийг боловсронгуй болгож, хувь хүний хэрэгцээг хангасан байдал, чанартай үйлчилгээ, гарц болон гүйцэтгэлд тулгуурлан санхүүжүүлнэ.	ССАЖЗЯ
	3.5.8.	Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн технологийн удирдлага, зохион байгуулалт үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн нэгдсэн бааз, платформ бий болгоно.	100%
	3.5.9.	Биеийн тамир, спортын технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжинэ.	ССАЖЗЯ
	3.5.10.	Биеийн тамир, спортын үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, шилжилт хөдөлгөөн, тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна.	90%

3.5.11.	Биеийн тамир, спортын хөтөлбөрөөр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, чиг үүргийг нь хараат бус, мэргэжлийн байгууллагад шилжүүлнэ.	ССАЖЗЯ
3.5.12.	Хүүхэд, залуучуудын авьяасыг нээх, шилдэг тамирчдыг бэлтгэх, хөгжүүлэх тогтолцоог боловсронгуй болгоно.	100%
3.5.13.	Биеийн тамир, спортын нэн шаардлагатай болон тэргүүлэх чиглэл, мэргэжлээр хүний нөөц бэлтгэх, орон нутгийн хэрэгцээг хангах чиглэлээр хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	ССАЖЗЯ
Хэрэгжилтийн дундаж		94.4%

Дөрөв. Дүгнэлт.

1. Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд хэрэгжилтийн дундаж 94.4%-ийн гүйцэтгэлтэй байна. Тус бодлогын баримт бичгийн 1.5 дугаар зорилтын 1.5.12-т заасан “Монголын уламжлалт спорт, наадам, наадгайг (бөх, сурын харваа, шагайн харваа гэх мэт) хөгжүүлэх, үндэсний баг, тамирчдаа дэмжих, морин болон тэмээн спортын (морин поло, тэмээн поло) төв байгуулж үндэсний багтай болох, гадаад, дотоодын баг, тамирчдыг урьж тоглуулах тогтолцоог хөгжүүлж, спортын зарим төрлийг олон улсын болон олимпын төрөлд оруулах, түүгээр дамжуулан өөрийн орны соёлыг түгээн дэлгэрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх” арга хэмжээний хэрэгжилт 2023 онд төлөвлөлт нь хийгдсэн боловч 2026 оны хэрэгжилт хангагдаагүй байна.

2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 3.5 дугаар зорилтын 3.5.6-д заасан “Биеийн тамир, спортын үйлчилгээний төрөл, гүйцэтгэлтэй уялдсан хараат бус магадлан итгэмжлэл бүхий чанарын удирдлагыг нэвтрүүлнэ”, 3.5.7-д заасан “Биеийн тамир, спортын санхүүжилтийг боловсронгуй болгож, хувь хүний хэрэгцээг хангасан байдал, чанартай үйлчилгээ, гарц болон гүйцэтгэлд тулгуурлан санхүүжүүлнэ”, 3.5.9-д заасан “Биеийн тамир, спортын технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг дэмжинэ”, 3.5.11-д заасан “Биеийн тамир, спортын хөтөлбөрөөр сургалт эрхэлж байгаа байгууллагад олгох тусгай зөвшөөрөл, магадлан итгэмжлэлд тавигдах шаардлагыг шинэчилж, чиг үүргийг нь хараат бус, мэргэжлийн байгууллагад шилжүүлнэ”, 3.5.13-т заасан “Биеийн тамир, спортын нэн шаардлагатай болон тэргүүлэх чиглэл, мэргэжлээр хүний нөөц бэлтгэх, орон нутгийн хэрэгцээг хангах чиглэлээр хүний нөөцийг төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ” зэрэг арга хэмжээ чиг үүргийн дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд шилжсэн тул цаашид энэхүү 5 арга хэмжээг Биеийн тамир, спортын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээнээс хасуулах талаар бодлого, төлөвлөлтийн баримт бичигт өөрчлөлт оруулах санал гаргах шаардлагатай байна.

Тав. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ / зөвлөмж /.

1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 1.5 дугаар зорилтын 1.5.12-т заасан Монголын уламжлалт спорт, наадам, наадгайг (бөх, сурын харваа, шагайн харваа гэх мэт) хөгжүүлэх, үндэсний баг, тамирчдаа дэмжих, морин болон тэмээн спортын (морин поло, тэмээн поло) төв байгуулж үндэсний багтай болох, гадаад, дотоодын баг, тамирчдыг урьж тоглуулах тогтолцоог хөгжүүлж, спортын зарим төрлийг олон улсын болон олимпын төрөлд

оруулах, түүгээр дамжуулан өөрийн орны соёлыг түгээн дэлгэрүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар, Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтэст;

2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж, холбогдох нэгжид шаардлага тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газарт;

3. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан “Үр дүн хүлээгдэж байгаа” арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж цаашид тайлагналтыг оновчтой, цаг хугацаандаа, тодорхой тайлагнаж, шалгуур үзүүлэлтийг 2026 оны зорилтот түвшинд хүргэхэд анхаарч ажиллахыг бүх газар хэлтсүүдэд тус тус зөвлөмж хүргүүлж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

2025.12.19

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын Их Хурлын 2024 оны “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 21 дүгээр тогтоолд тусгагдсан Биеийн тамир, спортын салбарт хамаарах арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулж, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээний үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг удирдлага болгов.

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2025 оны жилийн эцсийн тайлан ажлын бодит үр дүнг, хүрэх түвшинтэй харьцуулан хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийг үндэслэн дараах байдлаар дүгнэн тооцлоо.

1. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 85 хувь буюу түүнээс дээш бол “үр дүнтэй”;
2. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 60-84 хувь бол “үр дүн хүлээгдэж байгаа”;
3. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 30-59 хувь бол “үр дүн хангалтгүй”;
4. Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 0-29 хувь бол “үр дүн гараагүй”;
5. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Биеийн тамир, спортын салбарын хэрэгжүүлэхээр тусгагдсан 5 зорилт 15 арга хэмжээнээс 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд тайлагнавал зохих 10 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд 9 арга хэмжээ 85 хувиас дээш буюу “үр дүнтэй”, 1 арга хэмжээ 0-29 хувь буюу “үр дүн гараагүй”, хэрэгжилтийн дундаж 90 хувьтай буюу “үр дүнтэй” гэж дүгнэгдлээ.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Биеийн тамир, спортын салбарын хэрэгжүүлэхээр тусгагдсан 5 арга хэмжээ Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны чиг үүрэгт шилжсэн тул хэрэгжилт тайлагнагдаагүй байна.

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний хэрэгжилтийн дүн (хувиар)					Дундаж хувь
10	Үр дүнтэй	Үр дүн хүлээгдэж байгаа	Үр дүн хангалтгүй	Үр дүн гараагүй	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	
	85 хувиас дээш	60-84 хувь	30-59 хувь	0-29 хувь	-	90
	9	-	-	1		

№	Зорилт, арга хэмжээ		Гүйцэтгэл хувь
2.1.4.Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг			
2.1.4.1.Хүн амын бие бялдрын хөгжлийг хянах цахим технологи, өгөгдлийн системийг хөгжүүлж, нийтийн биеийн тамир, спортын орчны хүртээмжийг сайжруулна.			
1.	1	Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн технологийн төвийг байгуулж, идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг шинэчлэх мэдээллийн системийн программ хангамжийг хөгжүүлэн нэгдсэн сүлжээ бий болгох	ССАЖЗЯ
	2	Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг хянах сорилын төвийг аймаг, дүүрэг бүрд байгуулж, дата өгөгдөлд дүн шинжилгээ хийх спортын шинжлэх ухааны байгууллагын хүчин чадлыг сайжруулах	ССАЖЗЯ
	3	Спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх	ССАЖЗЯ
	4	Спортын барилга байгууламжийн хүртээмж, ачааллыг тодорхойлох аргачлал боловсруулж, хүртээмжийн түвшнийг тодорхойлох	ССАЖЗЯ
2.1.4.2.Спортын сургалт, дасгалжуулалтыг сайжруулж, үндэсний шигшээ багийн нөөц тамирчдыг бэлтгэн, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болон олимпын наадамд гаргасан амжилтыг хадгалж, Азийн наадамд улсын дүнгээр эхний 15 байрт орох алхмыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.			
2.	1	Анхан шатны спортын сургалт, дасгалжуулалтын үр дүнг хянах системийн программ хангамжийг хөгжүүлж, цахим технологид суурилсан спортын лабораторийг аймаг, дүүрэг бүрд байгуулах	ССАЖЗЯ
	2	Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн болон олимпын наадамд гаргасан амжилтыг хадгалахад чиглэсэн цогц арга хэмжээ хэрэгжүүлэх	100%
	3	Азийн наадамд улсын дүнгээр эхний 15 дугаар байрт ороход чиглэсэн цогц арга хэмжээ хэрэгжүүлэх	100%
	4	Өсвөр, залуучуудын ангиллын амжилтыг ахиулахад чиглэсэн цогц арга хэмжээ хэрэгжүүлэх	100%
	5	Допингийн эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх	100%
2.1.4.3.Спортын авьяасыг нээн илрүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлж, хөгжих боломжийг олгоно.			
3.	1	Анхан шатны спортын сургалт, дасгалжуулалтын үр дүнг сайжруулж, спортын шинжлэх ухаан, спортын анагаах ухааны тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	100%
	2	Спортын авьяасыг нээн илрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	100%
	3	Монгол Улсад зохион байгуулах олон улсын тэмцээнийг нэмэгдүүлэх	100%
2.1.4.4.Спортын санаачилга, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний хүрээнд идэвхтэй хөдөлгөөн болон эрүүл амьдралын хэв маягийг дэмжинэ.			

4.	1	Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилыг авч, хөгжлийн суурь үзүүлэлтийг сайжруулах	100%
	2	Хүн амын идэвхтэй хөдөлгөөн, спортын талаарх мэдлэг, хандлага, дадлыг нэмэгдүүлэх	100%
4.4.1.4. Эрүүл чийрэг, эх оронч, хариуцлагатай иргэнийг төлөвшүүлэх "Эх оронч монгол" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.			
5.	1	Эх оронч Монгол хөтөлбөр хэрэгжүүлэх	0%
Хэрэгжилтийн дундаж			90%

Дөрөв. Дүгнэлт.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд Биеийн тамир, спортын салбарын чиглэлээр тусгагдсан зорилт арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд шинэчлэгдэн батлагдсан журмын хүрээнд хяналт-шинжилгээ хийхэд 90%-ийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.4.1-р зорилтын "Биеийн тамир, спортын салбарын мэдээллийн технологийн төвийг байгуулж, идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг шинэчлэх мэдээллийн системийн программ хангамжийг хөгжүүлэн нэгдсэн сүлжээ бий болгох", "Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшнийг хянах сорилын төвийг аймаг, дүүрэг бүрд байгуулж, дата өгөгдөлд дүн шинжилгээ хийх спортын шинжлэх ухааны байгууллагын хүчин чадлыг сайжруулах", "Спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх", "Спортын барилга байгууламжийн хүртээмж, ачааллыг тодорхойлох аргачлал боловсруулж, хүртээмжийн түвшнийг тодорхойлох", "Анхан шатны спортын сургалт, дасгалжуулалтын үр дүнг хянах системийн программ хангамжийг хөгжүүлж, цахим технологид суурилсан спортын лабораторийг аймаг, дүүрэг бүрд байгуулах" эрэг арга хэмжээ чиг үүргийн дагуу Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд шилжсэн тул хэрэгжилт тайлагнаагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.1.4-р зорилтын "Эх оронч Монгол хөтөлбөр хэрэгжүүлэх" зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр хөтөлбөр, уулзалт, судалгаа зэрэг зохион байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн боловч тухайн арга хэмжээний төсөв 2025 оны төсвийн тодотголоор хэмнэгдэж хасагдсан үндэслэлээр хэрэгжилт хангалтгүй байна.

Мөн 2023, 2024 оны жилийн эцсийн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд туссан зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

Тав. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ / зөвлөмж /.

Бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлэх зорилго, зорилт тус бүрийн урьдчилсан судалгааг бүрэн хийж, хэрэгжүүлэх ажлын хүрээг зөв тодорхойлж, шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь болон зорилтот түвшинг оновчтой төлөвлөх, зорилт, арга хэмжээг хариуцсан нэгжүүд шалгуур үзүүлэлтийн дагуу иж бүрэн, үнэн зөв тайлагнаж, шалтгаан түүний үр дагаврыг тодорхойлж хэвшихийг бүх газар, хэлтсийн дарга нарт;

Санхүүжилтийн асуудлаас шийдвэрлэгдээгүй арга хэмжээнүүд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн эцсийн үр дүнд сөргөөр нөлөөлж байгаа тул

2026 оны төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээ тусгаж төлөвлөн ажиллахыг Төрийн, захиргааны удирдлагын газар, Бодлого төлөвлөлтийн газарт;

Цаашид газар, хэлтсийн дарга нарт төлөвлөсөн ажлынхаа гүйцэтгэлд хариуцлагатай хандах, хяналт-шинжилгээний тайланд туссан зөвлөмжийн биелэлтийг хангаж хэвшихийг тус тус зөвлөмж болгож байна.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

**МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2025.12.19

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн Биеийн тамир, спортын улсын хороо хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийг төлөвлөсөн зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хэрэгжилт харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээний зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үндэслэл, үнэлгээний арга зүй

Хяналт-шинжилгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг удирдлага болгов.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2025 оны жилийн эцсийн тайланг тухайн зорилтын хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг үндэслэн дараах байдлаар дүгнэн тооцлоо.

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт нь зорилтот түвшний 85 хувиас дээш бол “үр дүн гарсан”;
2. Бодлогын баримт бичгийн хэрэгжилт нь зорилтот түвшний 85 хувьд хүрээгүй бол “үр дүнгүй”.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Биеийн тамир, спортын салбарын хүрээнд 1 зорилт 4 арга хэмжээний хэрэгжилтийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд тайлагнавал зохих 4 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхэд 2 арга хэмжээ 85 хувиас дээш буюу “үр дүн гарсан” 2 арга хэмжээ “үр дүнгүй” гэж дүгнэгдлээ.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 3.5-р зорилтын 3.5.2-т заагдсан “Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмж нэмэгдэнэ” арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын чиг үүрэг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд харьяалагдаж, холбогдох статистик тоон мэдээлэл 2026 онд гарах тул хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй.

Хүснэгт 1.

Нийт арга хэмжээ	Арга хэмжээний хэрэгжилтийн дүн (хувиар)		Дундаж хувь
	Үр дүн гарсан	Үр дүнгүй	
4	85 хувиас дээш	85 хувьд хүрээгүй	87.5
	2	2	

№	Дэс дугаар	Зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэл хувь
3. ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА			
3.5. Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.			
1.	3.5.1	Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй, уян хатан тогтолцоог бүрдүүлнэ.	70%
	3.5.2	Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмж нэмэгдэнэ.	80%
	3.5.3.	Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.	100%
	3.5.4.	Мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын чадвар, амжилт дээшилсэн байна	100%
Хэрэгжилтийн дундаж			87.5%

Дөрөв. Дүгнэлт.

Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтэд шинэчлэгдэн батлагдсан журмын хүрээнд хяналт-шинжилгээ хийхэд хэрэгжилтийн дундаж 87.5 хувьтай буюу “Үр дүн гарсан” гэж дүгнэгдсэн байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд зааснаар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь дунд хугацааны Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг юм. Тус баримт бичгийн хувьд 2025 онд хэрэгжих хугацаа дууссан бодлогын баримт бичигт хамаарагдаж байна. Биеийн тамир, спортын улсын хорооны энэхүү 5 жилийн хугацаанд бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал, арга хэмжээг төлөвлөсөн зорилт, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилгот түвшин түүнийг хэрэгжүүлж ирсэн байдал зэргийг нэгтгэн дүгнэхэд тухайн арга хэмжээнд шаардлагатай төсвийн уялдаа хамаарлыг бодитой, оновчтой төлөвлөөгүй, мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилтыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх” гэж заасны дагуу арга хэмжээг он тус бүрээр шалгуур үзүүлэлттэйгээр баталж, хэрэгжүүлээгүй байна.

Тав. Зөвлөмж

Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх Хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичгийн төлөвлөлтийн явцад урьдчилсан үнэлгээ хийж, хөгжлийн бодлого, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг бодит нөхцөл байдалд тулгуурлан оновчтой төлөвлөхөд дараах зөвлөмжийг бүх газар, хэлтэст хүргүүлж байна. Үүнд:

1. Бодлогын баримт бичгийн шалгуур үзүүлэлт оновчтой эсэхийг тодорхойлж, төлөвлөлтийн алдаа гаргахгүй байх;

2. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгааг хийж, төсөв хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгах саналыг хүргүүлж, санхүүжилтийн эх үүсвэрүүдийг шийдүүлж, хэрэгжүүлэх.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС